

**МӨРДӨН БАЙЦААХ АЛБАНААС “ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ САЛБАР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 06 дугаар сарын 09-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт		
<i>Зорилт-1: Хууль тогтоомжийг сурталчилах чиглэлээр</i>					
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх.	<p>Тус албаны төвийн хэлтсийн 117, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах тасгийн 525 алба хаагчдыг Авлигатай тэмцэх газрын “АТГ-Олон нийтийн төв”, АТГ-ын дэргэдэх олон Олон нийтийн зөвлөл” нэртэй фэйсбүүкийн пэйж хуудсанд нэгдүүлэх ажлыг зохион байгуулж, уг пэйж хуудсанд тавигдсан 27 ведио мэдээ, “Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн хэрэгцээ, шаардлага сэдэвт хэлэлцүүлэг, 18 шторк, 5 инфографик, 31 нийтлэл, 4 теле зохиомж, 33 постер, 78 дэмжих мэдээ мэдээлэл, нийт 197 мэдээллийг тус албаны “Мөрдөн байцаах алба”, “МБА-Албан хэрэгцээнд” олон нийтийн сүлжээ /facebook/ хуудас, www.mba.police.gov сайт, иргэд угтах танхимын “Ухаалаг дэлгэц” зэрэгт байршуулсныг 36.237 хэрэглэгч хуваалцаж, 11.076 лайк дарж, 5714 эерэг сэтгэгдэл бичсэн байна.</p> <p>Мөн Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн “Авлигаас ангид байх, авлига, ашиг сонирхолын талаар мэдээлэх” зурагт хуудсыг байгууллагын албан өрөө бүрийн хаалга болон алба хаагч бүрийн компьютерт нааж, иргэдэд үзэгдэх боломжтой хэсэгт байршуулсан.</p>	100	5
2		1.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг албаны онцлогт тохируулан зохион байгуулах.	Авлигатай тэмцэх газраас НҮБ-ын уриа, зорилттой уялдуулан зохион байгуулж байгаа “Зөв, зөв шудрага зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс “Таны	80	4

			<p>эрх, таны оролцоо”, “Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” соён гэгээрүүлэх өдөрлөгийг Дотоод хэргийн их сургуулийн төгсөх дамжааны 500 гаруй оюутны дунд зохион байгуулж, уг өдөрлөгийн арга хэмжээг дэмжиж тус албаны Тусгай субъектын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Баттулга лекц уншиж, сонсож суралцагчдын асуултад хариулсан.</p> <p>Тус албаны Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс санаачлан “Эр цэргийн баяр”-ын өдрийг тохиолдуулан 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн алба хаагчдын дунд албандаа хандах хандлагыг сайжруулах, авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдүүлэх зорилгоор “Хувь хүний төлөвшил-Хандлага” сэдэвт өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, лектор Б.Азбаяраар “Харилцаа, хандлага зан үйлд нөлөөлөх нь” сэдэвт лекц уншиж, алба хаагчидтай харилцан яриа өрнүүлж, Сүлд чуулгын уран бүтээлчид ая дуугаа өргөн, өгөгдсөн сэдвийн хүрээнд баг бүр бусдад ойлгогдохуйц байдлаар хариултаа өгч, энэ төрлийн гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаар ойлголтоо нэмэгдүүлсэн онцлог арга хэмжээ болсон.</p> <p>Нийслэлийн сургалт, судалгааны төвтэй хамтран нэгдмэл уур амьсгал, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, шудрага, зөв үйлдлийг дэмжиж, бурууг бага дээр нь засч залруулах сэдэл, дадал олгох “Хүчирхэг багийг бий болгох хамтын ажиллагаа” сэдвээр “Дейл Карнеги трэйнинг” үүсгэн байгуулагч, Монгол дахь захирал Б.Энхболдоор сургалт зохион байгуулж, бага, хамт олны ажиллагааг нэмэгдүүлсэн.</p>		
<i>Зорилт-2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах чиглэлээр</i>					
3	Албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах.	2.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа бүрэн хамруулах.	<p>Авлигатай тэмцэх газраас 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулсан давтан сургалтад албаны нууц аюулгүй байдал хариуцсан ахлах мөрдөгч, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн нар, 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг бодлого, үйл ажиллагаа” сэдэвт сургагч багш нарыг чадавхжуулах 2 өдрийн давтан сургалтад хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн тус тус хамрагдсан.</p> <p>Авлигатай тэмцэх газартай хамтран 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр цахим сургалтыг авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 4 сэдвийн</p>	100	5

			хүрээнд зохион байгуулж, төвийн хэлтсийн 86 алба хаагчийг хамруулсан.		
Зорилт-3: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр					
4	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх.	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн “Зөвлөмж”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах. /Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Л.Нямгэрэлээс 2022 оны 2/44 албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг Үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах./	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Л.Нямгэрэлээс 2022 оны 2/44 албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг Үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх 11 заалттай төлөвлөгөө гарган, хариуцах албан тушаалтнуудыг эзэнжүүлж, хэрэгжилтийг тайланд хугацаанд дүгнэхэд 86.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөлөгөөний биелэлтийг тусад нь тайлагнаж Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.	86	4.3
		3.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн дагуу арга хэмжээ зохион байгуулж, хуулийн хугацаанд хариу хүргүүлэх.	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Мөнхнаранд холбогдуулан ирүүлсэн 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн №54 дугаар “Мөрдөгчийн мэдэгдэл”-ийг хүлээн авч энэ оны 04 дүгээр сарын 29-ний өдөр албаны төвийн хэлтсийн өглөөний шуурхай яриан дээр нийт алба хаагчдад танилцуулж, 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12/1-2311 дугаар албан бичгээр харьяа нэгжүүдэд хүргүүлэн мэдэгдэлийн мөрөөр соён гэгээрүүлэх, урьдчилсан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг чиглэлийг хүргүүлж, биелэлт үр дүнг тооцож, хариуг хуульд заасан хугацаанд Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт хүргүүлсэн. Мэдэгдлийн дагуу тус албаны харьяа 54 нэгжийн алба хаагч нарт мэдэгдэлийг танилцуулж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй албан тушаалтнуудад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйл /Өмгөөлөгч оролцуулах/, 25.3 дугаар зүйл /Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах/, мөн хуулийн 18 дугаар бүлэг Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөн хуулийн 16.1 дүгээр зүйл /Нотлох баримт/, 16.14 дүгээр зүйл /Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх/-д заасан тодорхой төрлийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа хууль тогтоомж, эрх зүйн актыг судалж үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй мөрдөж ажиллах талаар сургалтыг	100	5

			<p>зохион байгуулж, нэгжүүд тухайн зөрчлийн талаар зөвхөн тус албаны харьяа мөрдөгчдөд сургалтыг зохион байгуулахаас гадна мөрдөн шалгах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчдад хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй аливаа эрсдэл ялангуяа нотлох баримт хуурамчаар үйлдэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, бусдын нөлөөнд автахгүй байхад чиглэгдсэн дотоодын сургалтыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулан ажилласан..</p>		
		<p>3.3. Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах.</p>	<p>Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдлийг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах хэлтэс, тасаг, хэсгийн дарга нарт алба бичгээр хүргүүлж, “МБА-Албан хэрэгцээнд” хаалттай группт байршуулан алба хаагч нарт танилцуулсан. “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр нийт мөрдөгч нарт танхимаар 1 удаа, цахимаар 1 удаа сургалт зохион байгуулж, нэгжийн дарга нарт дотоодоо сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион явуулах зөвлөмж хүргүүлж, нотломжийг авч албажуулсан. Тус албанаас Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэстэй хамтран улирал бүр цагдаагийн байгууллагын нийт бүрэлдэхүүнээс Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжоор тестийн сорилыг боловсруулан шалгалтын цахимаар зохион байгуулж, үнэлэлт дүгнэлт өгч, дараагийн шалгалтын тестээ боловсруулан ажиллаж байна.</p> <p>Энэ онд алба хаагчдыг сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын саналыг 174 алба хаагчдаас авч, нэгтгэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Төлөвлөөний дагуу мөрдөн шалгах ажиллагаанд “Хүний эрхийг хангахад анхаарах асуудлаар” ХЭҮК-той хамтран сургалтыг албаны хэмжээнд зохион байгуулсан. ЦЕГ-аас зохион байгуулж буй “Хүний эрх ба алба хаагчийн эрх үүрэг” сэдэвт сургалтыг тус албаны хяналт шалгалт хариуцсан ахлах мөрдөгч, цагдаагийн хурандаа Б.Энхбат нийслэл, орон нутагт зохион байгуулж байна.</p> <p>Нийслэлийн прокурорын газар, Мөрдөн байцаах албаны хамтарсан зөвлөгөөнийг энэ оны 02 дугаар сарын 23-ны өдөр “Мөрдөн шалгах ажиллагааны чанарыг дээшлүүлэх, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах” чиглэлээр зохион байгуулсан.</p> <p>Тус албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс Хэнтий, Завхан, Хөвсгөл, Баянхонгор аймгийн</p>	95	4.7

			<p>нийт 242 алба хаагч нарт “Цагдаагийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд анхаарах асуудал”, Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тухай ойлголт, түүний хор хөнөөл, анхаарах асуудал, “Нотлох баримтын ойлголт, хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” сэдвээр сургалтыг зохион байгуулан, цаашид цагдаагийн алба хаагчдаас үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой хичээл сургалтыг зохион байгуулан үйл ажиллагаандаа тогтмолжуулан ажиллаж байна</p> <p>Албаны хэмжээнд энэ оны эхний 01 дүгээр улирлын байдлаар сахилгын шийтгэл авагдсан нийслэл дэх нэгжийн алба хаагчдыг “Сахилга, ёс зүйн орон тооны бус зөвлөл”-ийн ээлжит хуралдаанаар биечлэн оруулж, гаргасан зөрчил дутагдлын шалтгаан нөхцлийг нэг бүрчлэн хэлэлцэн, үүрэг чиглэл өгч, “Ажлаас халшрах хам шинж түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалтыг зохион байгуулсан.</p>		
Зорилт-4 : Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр					
5	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.	4.1. “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны салбар төлөвлөгөө”-ний биелэлтийг нэгтгэн дүгнэж, нотломжийн хамт Аюулгүй байдлын хэлтэст тайлагнах.	<p>Энэ онд “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр батлагдаж ирсэн тул салбар төлөвлөгөөг 45 заалттайгаар боловсруулан 04 дүгээр сарын 12-ны өдөр батлуулсан.</p> <p>Авлигаас урьдчилан сэргийлэх орон тооны бус салбар зөвлөлийн анхдугаар хуралдааныг энэ оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хуралдуулж, салбар төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн, заалт бүрийг эзэнжүүлж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээгээ тодорхойлж, хурлаар 8 асуудлыг шийдвэрлэн, төлөвлөөний хэрэгжилийн 95.1 хувьтай Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.</p>	95	4.7
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт					
6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах	8 5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах”, 9 дүгээр зүйлд заасан “Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх тухай” заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлж ажиллах.	<p>Мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлөх, саад учруулж болзошгүй байдал нөлөөллийн хуудас бичих, ЦБҮАЖ код 139 Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд албаны даргын энэ оны 01 тоот албан даалгаварт алба хаагчдын Сахилга, ёс зүйн байдлыг тусгайлан бүлэг болгон зааж оруулан биелэлт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон ажиллаж байна.</p> <p>Тус албанаас нэгжүүдэд мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийн шийдвэрлэлт, ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн тохиолдолд нөлөөллийн хуудас бичүүлэх, энэ ажиллагаанд дарга нарын хяналтыг сайжруулах талаар ажлын чиглэл хүргүүлсэн</p>	100	5

	боломжоор хангах.		бөгөөд тайлангийн хугацаанд алба хаагчид хөндлөнгөөс нөлөөлөх 1 үйлдэл гарсаныг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газарт мэдэгдсэн.		
7	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	8.10. Цагдаагийн алба хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, сахилга ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг 24 цагийн хугацаанд тасралтгүй шуурхай хүлээн авах суурин телефон 70191441, 70191430 утсыг жижүүрт байрлуулж, ирүүлсэн мэдээллийг харьяалах хэлтэст шилжүүлэн хянан шалгах, хариуцлага хүлээлгэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	Мөрдөн байцаах албаны удирдлагаас хуваарийн дагуу иргэдтэй уулзаж, алба хаагч, ажилтан нь иргэдийг төв байрны үүдний хэсэг дэх иргэдийн танхимаас хүлээн авч, “Иргэд хүлээн авах өрөө”-нд уулзаж, уулзалтын өрөөнд “Саналын хайрцаг”-ийг иргэдэд харагдахуйц, санал хүсэлтээ хийхэд хялбар, гар хүрэхүйц газарт байршуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна. “Саналын хайрцаг”-ийг өргөдөл, гомдол хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн хариуцаж, 7 хоногийн даваа, пүрэв гараг бүрт шалгаж санал, хүсэлтийг албаны даргад танилцуулан ажиллаж байна. Албаны 70191430, 70191441 дугаарын утсанд мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллийг тухай бүр хүлээн авах талаар албаны сайт, пэйж хуудас зэргээр цахим орчинд байршуул хоногийн нөхцөл байдалд тусган ажиллахад алба хаагчийн сахилга, ёс зүй зөрчсөн санал, хүсэлт ирүүлээгүй байна. Иргэдээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, авлига, албан тушаалын шинжтэй мэдээллийг цахимаар хүлээн авч байгаа талаар сайт, фэйсбүүкийн пэйж хуудас, албаны байрны мэдээллийн самбар, “Ухаалаг дэлгэц”-д зурган мэдээлэл, шторк, ведио байдлаар байршуулан, мэдээллээ тухай бүр шинэчлэн ажилласнаар байгууллагын үйл ажиллагаа иргэдэд нээлттэй ил тод болж цахимаар гэмт хэргийн шинжтэй 2 гомдол мэдээлэл, 12 хүсэлтийн хариуг хүлээн авсан байна. Тус албаны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг иргэдээс цахимаар хүлээн авах зорилгоор http://mbg.police.gov.mn/ , http://sid@police.gov.mn сайтуудыг ашиглаж байна.	100	5
8	Нийт 9 ажил, арга хэмжээний хэрэгжилт 95.1 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнав.				

МӨРДӨН БАЙЦААХ АЛБА